# БЗДХ-ын кабинетаар үйлчлүүлэгч эмэгтэйчүүдийн дунд микоплазм, уреаплазмын халдвар илрүүлж, эмнэлзүйг судалсан дүн

*Б.Жүгдэржав[1,2], Г.Өнөрсайхан[3], О.Энхжаргал[2], Б.Пүрэвдагва[2], Ч.Эрдэнэчимэг[2], П.Нямдаваа[4], О.Баатархүү[1,4]*

*[1]АШУҮИС-ийн АУС-ийн Халдварт өвчин судлалын тэнхим*
*[2]Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв*
*[3]"Гялс" Анагаах Ухааны Төв*
*[4]Монголын Анагаах Ухааны Академи*

**Үндэслэл:** Манай улсад бэлгийн замаар дамжих халдвар нийт халдварт өвчний дотор тэргүүлэх байр эзэлж, тогтвортой өндөр бүртгэгдэж байна. БЗДХ нь 30 гаруй төрлийн нян, вирүс, шимэгчдээр үүсгэгддэг боловч манай оронд шээс бэлгийн замын уреаплазм, микоплазмын халдваруудыг зөвхөн судалгаа шинжилгээний чанартай харьцангуй цөөн тохиолдлыг оношлон бүртгэж байна. Гэвч эмэгтэйчүүдэд өвөрмөц бус шалтгаантай үрэвслийн шалтгааны дийлэнх нь уреаплазм, микоплазмын халдварын шалтгаантай байдаг байна.

**Зорилго:** БЗДХ-ын кабинетаар үйлчлүүлэгч эмэгтэйчүүдийн дунд нөхцөлт эмгэгтөрөгч болох Mycoplasma hominis (MH), Ureaplasma urealyticum (UU), Ureaplasma parvum (UP) гэсэн үүсгэгчийг илрүүлж, судлах

**Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй:** ХӨСҮТ-ийн ДОХ, БЗДХ-ын тандалт судалгааны албаны амбулаториор үйлчлүүлсэн нийт 582 эмэгтэйг сонгон судалгаанд хамруулсан. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдээс үтрээ, умайн хүзүүний арчдасын шинжилгээ авч Mycoplasma hominis (MH), Ureaplasma urealyticum (UU), Ureaplasma parvum (UP) гэсэн үүсгэгчид илрүүлэх шинжилгээг нүклейн хүчил илрүүлэх микро-эррэйн аргаар [Flow-through Micro-array, DiagCor, HK] хийж үр дүнг тооцсон.

**Үр дүн:** Эмэгтэйчүүдийн үтрээ, умайн хүзүүнээс авсан сорьцонд үүсгэгч тодорхойлоход M.hominis 23.9%-д, U.urealyticum U.parvum 55.3%-д илэрсэн. БЗҮӨ-ний шинж тэмдэгтэй 420 эмэгтэйд M.hominis 161(38.7%), U.urealyticum U.parvum 213(50.8%)-д БЗҮӨ-ний шинж тэмдэггүй 162 эмэгтэйд M.hominis 54(33.3%), U.urealyticum U.parvum 109(67.3%) ($p<0.001$) илэрсэн. M.hominis дангаар илэрсэн эмэгтэйчүүдэд эмнэлзүйн үзлэгээр 70.2%-д умайн хүзүүний үрэвсэл, 46.8%-д үтрээний үрэвслийн шинж илэрсэн байна. Харин U.urealyticum/U.parvum дан халдварын үед 53.2%-д умайн хүзүүний үрэвсэл, 28.3%-д үтрээний үрэвслийн шинж илэрсэн байна

**Дүгнэлт:**

1. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн дунд микоплазм, уреаплазмын халдварын тархалт өндөр (29.3% ба 55.3%) тодорхойлогдож байна.
2. Нөхцөлт эмгэгтөрөгч болох M.hominis, U.urealyticum/U.parvum-ийн халдвар дангаар илэрсэн эмэгтэйчүүдэд үтрээ умайн хүзүүний үрэвслийн эмнэлзүйн шинж 70% хүртэл илэрч байгаа нь эдгээр нөхцөлт эмгэгтөрөгчид эмэгтэйчүүдэд өвөрмөц бус үүсгэгчээр үүсгэгдсэн үрэвслийн нилээдгүй шалтгаан болж байх боломжтойг харуулж байна

**Түлхүүр үгс:** Нэвчүүлэн эрлийзжүүлэх толбот эгнээний арга, Бэлгийн замын үрэвсэлт өвчин, Mycoplasma hominis (MH), Ureaplasma urealyticum (UU), Ureaplasma parvum (UP)

# Results of detection Mycoplasma, Ureaplasma among female STI clients and clinical symptoms

*Jugderjav B[1,2], Unursaikhan G[3], Enkhjargal O[2], Purevdagva B[2], Erdenechimeg Ch[2], Nymadawa P[4], Baatarkhuu O[1,4],*

*[1]Mongolian National University of Medical Sciences*
*[2]National Center for Communicable Diseases, Ulaanbaatar, Mongolia*
*[3]"Gyals" Medical Center*
*[4]Mongolian Academy of Medical Sciences*

**Introduction:** Sexually transmitted infections are one of the leading infectious diseases and recorded a fairly high incidence in our country, Although STIs are caused by more than 30 types of bacteria, viruses and parasites, a relatively few cases of incidence of urogenital ureaplasma and mycoplasma infections are diagnosed only for research purpose and registered. However, the majority of non-specific inflammation in women are caused by ureaplasma and mycoplasma infections.

**Purpose:** To identify and investigate conditional pathogenic Mycoplasma hominis (MH), Ureaplasma urealyticum (UU), and Ureaplasma parvum (UP) among female clients of STI cabinet.

**Materials and methods:** Total 582 women, who had been serviced STI department of National Center for Communicable Diseases, were selected and involved in the study. Swab samples from the vagina and cervix were taken and detection of Mycoplasma hominis (MH), Ureaplasma urealyticum (UU), and Ureaplasma parvum (UP) by Flow-through Micro-array method based on nucleic acid [Flow-through Micro-array, DiagCor, HK] and determined the results.

**Results:** For detecting pathogen, M.hominis was detected in 23.9% and U.urealyticum and U.parvum in 55.3% of the specimens, taken from the vagina and cervix in women. M.hominis was detected in161 (38.7%), U.urealyticum U.parvum was detected in 213 (50.8%) in 420 women with STD symptom, whereas M.hominis was detected in 54 (33.3%), U.urealyticum U. parvum was detected in 109 (67.3%) ($p<0.001$) in 162 asymptomatic women. In women, detected M.hominis alone, cervical inflammation in 70.2% and vaginal inflammation in 46.8% were observed by clinical examination. However, cervicitis was found in 53.2% and vaginal inflammation in 28.3% was found in case of single infection with U.urealyticum/U.parvum.

**Conclusion:**

1. The prevalence of mycoplasma and ureaplasma infections was determined high (29.3% and 55.3%) among the women, surveyed in the study.
2. Clinical signs of vaginitis and cervicitis was observed up to 70% in women, infected with conditional pathogenic M.hominis, U.urealyticum / U.parvum alone, indicating that these conditional pathogens might be the major cause of nonspecific inflammation in women.

**Keywords:** Flow-through Micro-array method, Sexually transmitted disease, Mycoplasma hominis (MH), Ureaplasma urealyticum (UU) and Ureaplasma parvum (UP)